



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ЧАНДМАНЬ-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 09 сарын 09 өдөр

Дугаар А/65

Хөхөө

2024 оны ээлжит цэрэг татлагын ажлыг  
удирдан зохион байгуулж явуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Цэргийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь заалт, аймгийн Засаг даргын 2024 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн А/432 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2024 оны цэрэг татлага, эмнэлгийн үзлэгийг 2024 оны 10 дугаар сарын 05-ны өдөр сумын Соёлын төвд зохион байгуулан явуулсугай.

2.2024 оны цэрэг татлага, эмнэлгийн үзлэгийн бэлтгэлийг ханган, зохион байгуулж явуулах комиссыг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Ж. Баасанжав – Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүд: П. Оргил – Шивэрт багийн Засаг дарга

З.Мөнхбат – Ёлгос багийн Засаг дарга

Н.Эрдэнэбаяр – Улаан-Асга багийн Засаг дарга

З. Дашням – Хөхөө багийн Засаг дарга

Ц. Гансүх –Хайрхантолгой багийн Засаг дарга

Ц.Цэрэнчимэд – Эрүүл мэндийн төвийн эмч

Л.Бумбаяр – Тархвар зүйч

Г. Чулуунбаатар – Газрын даамал

Б. Азжаргал – Архив бичиг хэргийн эрхлэгч

М.Буяннэмэх - Хэсгийн төлөөлөгч

М.Насанжаргал - Насан туршийн боловсрол олгох төвийн захирал

3.Сумын хэмжээнд 18-26 насны цэргийн үүрэгтнийг цэрэг татлагын эмнэлгийн үзлэгт бүрэн хамруулж, аймгийн Цэргийн штабаас өгсөн зөвлөмжийн дагуу чанартай зохион байгуулж, биелэлт, үр дүнг танилцуулахыг комисст үүрэг болгосугай.

4.Цэрэг татлагын эмнэлгийн үзлэгээр эмгэгтэй гарсан цэргийн насны залуучуудыг эмчилж эрүүлжүүлэх, цэргийн насны залуучуудын боловсролын судалгааг гарган, сургалтанд хамруулж анхан шатны боловсрол олгох, мэдлэг чадварыг дээшлүүлэх чиглэлээр тодорхой ажил зохион байгуулахыг Эрүүл мэндийн төв(Ц.Цэрэнчимэд), Насан туршийн боловсрол олгох төвийн захирал (М.Насанжаргал) нарт даалгасугай.

ДАРГА



Л.ЭНХЖАРГАЛ